

## МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ОЛОН НИЙТИЙН ДИПЛОМАТ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Д. Долгорсүрэн\*

**М**онгол Улсын Их Хурлаас 1994 онд батлан гаргасан “Монгол Улсын Гадаад Бодлогын Үзэл Баримтлал”-д Монгол улсын гадаад бодлогыг тодорхойлохдоо “Монгол улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг улс төр-дипломатын аргаар хангах . . . явдал нь гадаад бодлогын тэргүүлэх чиглэл байна.<sup>1</sup>” гэж заажээ. 2011 оны 2 сарын 10 - нд Монгол Улсын Их Хурлаас гаргасан 10 тогтоолоор уг үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулсан бөгөөд нийтлэг үндэслэлд нь “Монгол улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр, дипломатын аргаар хангах нь гадаад бодлогын тэргүүлэх зорилт мөн<sup>2</sup>” хэмээн тодотгон зааж өгчээ. Дээрх үзэл баримтлалыг хэрэгжүүлэх явцад манай улсын гадаад харилцаа өргөжин тэлж, байр суурь нь бэхжин, нэр хүнд нь олон улсад өсөн нэмэгдсэнийг бид бэлхнээ мэдэх билээ. Үүний тод илрэл нь 1994 оноос хойш Монгол улс 30 гаруй оронтой дипломат харилцаа тогтоож, одоо нийт 164 улстай дипломат харилцаатай болоод байгаа явдал юм. Монгол орон “хаалттай улс” гэсэн нэрээс ангижирч, олон улсын хамтын нийгэмлэгт “ардчилсан, нээлттэй улс” хэмээн тооцогдох болсон билээ. Тэгэхээр манай улсын гадаад бодлого тодорхой хэмжээгээр үр дүнтэй хэрэгжиж байна.

Гадаад бодлогыг хэрэгжүүлэх гол арга нь дипломат ажиллагаа байдаг. “Монгол Улсын Гадаад Бодлогын Үзэл Баримтлал”-д тусгасан “ . . . улсынхаа аюулгүй байдлыг дипломатын аргаар хангана “ гэдэг нь чухам юу гэсэн үг вэ?

Юуны өмнө хүн төрөлхтөний хувьд хамгийн чухал суурь асуудлын нэг байсаар ирсэн аюулгүй, амар тайван аж төрнө гэдэг зөвхөн нэг улс үндэстний бус, нийт дэлхий дахины амин чухал хүсэл эрмэлзлэл билээ. Аюулгүй байдлыг хэрхэн бүрдүүлж, ямар арга замаар түүнийг хангах вэ гэсэн асуулт дэлхийн олон орны судлаачдын анхаарлыг татаж байгаа учраас төрийн удирдагчдын хувьд энэ ойлголтын талаар өнөө үед шинжлэх ухааны түвшинд мэдлэг, мэдээлэл, нэгдсэн байр суурьтай байж, их хариуцлага хүлээх учиртай ойлголт гэж үзнэ. Аюулгүй байдал

\* МУИС, ОУХС-ийн ахлах багш, докторант

1. “Монгол Улсын Гадаад Бодлогын Үзэл Баримтлал”, 1994

2. “Монгол Улсын Гадаад Бодлогын Үзэл Баримтлал”, 2011

МУ-ын аюулгүй байдлыг хангахад олон нийтийн дипломат ажиллагааны гүйцэтгэх үүрэг  
гэдэг ойлголтод улс төр, цэрэг, дайны заналхийлэлтэй холбоотой уламжлалт асуудлыг хэлэлцэж ирсэн хэдий ч эдүгээ энэ талаарх ойлголт улам өргөжиж хүний, эдийн засгийн, хүрээлэн байгаа орчны, хүнсний, мэдээллийн аюулгүй байдал зэрэг олон салбарыг хамрах болсон билээ. Монгол улсын “Үндэсний Аюулгүй Байдлын тухай” хуульд “Үндэсний аюулгүй байдал гэж Монгол улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ”<sup>3</sup> гэжээ. Мөн Монгол улсын Их Хурлын 2010 оны 7 сарын 15-ны 48-р тогтоолоор “Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлал”-ын нийтлэг үндэслэлийн 1.1-д үндэсний аюулгүй байдлыг тодорхойлохдоо “Монгол улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ”<sup>4</sup> гэжээ.

Аливаа улсын хувьд гадаад, дотоод таатай нөхцөл бүрдэнэ гэдэг нь тухайн улсын жирийн иргэд дотооддоо ч, хилийн чанадад ч адилхан хэвийн нөхцөлд ажиллаж амьдарч, улс төр, эдийн засаг, санхүү, эрүүл мэндийн хувьд аюулгүй, эрх тэгш, тааламжтай амьдрах боломжоор хангагдсан байхыг хэлнэ. Түүнчлэн тухайн улс бие даасан тусгаар улс байж, хил хязгаар, газар нутгийнхаа бүрэн бүтэн байдлыг баттай хамгаалж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн улс гүрэн гэдэг утгаараа дэлхийн хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд ижил тэгш эрхтэй оролцож, иргэд нь санал бодлоо илэрхийлэх, эрхээ хамгаалуулах, иргэд байгууллагууд нь олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулах бүрэн эрхээр хангагдсан байхыг хэлэх ёстой. Үүний тулд улс гүрнүүд олон улсын харилцаанд оролцохдоо гадаад бодлогоороо дамжуулан дотоод бодлогоо илэрхийлэн нээн гаргаж байдаг. Тиймээс дээрх таатай нөхцлүүд бүрдэж баталгаажсан үед л улсын аюулгүй байдал хангагдлаа гэж үзэж болох юм.

Аливаа улсын төр засгийн гол үүрэг, зорилго нь ард иргэдийнхээ энх тайван, аюулгүй байдлыг хангах явдал юм. Тэгвэл Монгол улсын төрийн үүрэг нь ч гэсэн иргэдийнхээ амар тайван, аюулгүй байдлыг хангах явдал юм. Монгол Улсын Үндсэн Хуулийн I-р бүлгийн 11-р зүйлд “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”<sup>5</sup> гэж заасан байдаг.

Монгол улс аюулгүй байдлаа дипломатын аргаар хэрхэн хангах вэ? Энэхүү асуултанд хариулахын тулд дипломат арга ажиллагаа нь улсын аюулгүй байдалд ямар хамааралтай болохыг судалж үзэхийг зорилоо. Монгол улсын Гадаад Бодлогын Үзэл Баримтлал дахь “Монгол улсын

3. “Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын тухай хууль”, 2001.12.27., Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл. УБ, 2004. 35-р тал

4. “Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлал”, 2010-7-15, УБ.

5. “Монгол Улсын Үндсэн Хууль” 1-р бүлэг, 11-р зүйл

МУ-ын аюулгүй байдлыг хангахад олон нийтийн дипломат ажиллагааны гүйцэтгэх үүрэг аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг улс төр-дипломатын аргаар хангах ...” гэсэн заалтын дипломатын аргаар хангах гэдэг нь улсынхаа аюулгүй байдлыг дипломат ажиллагааг явуулах арга замаар хангана гэсэн үг юм. Тэгэхээр дипломат ажиллагаа гэж юу болох, үүнийг эрдэмтэн мэргэд хэрхэн тодорхойлж, энэ үгийг хэзээнээс олон улсын харилцаанд хэрэглэдэг болсныг мэдэх шаардлага урган гарч байна.

“Дипломат ажиллагаа” гэсэн энэхүү нэр томъёог Европын хэд хэдэн оронд Людовик XIV хааны элчин сайдаар томилогдон ажиллаж байсан, чухал ач холбогдол бүхий олон яриа хэлэлцээрт амжилттай оролцож явсан Францын дипломатч Франсуа Кальер анх хэрэглэсэн гэдэг. Тэрбээр 1716 онд бичсэн “Улс орнуудтай хэлэлцээ явуулах арга” нэртэй номдоо дээрх нэр томъёог оруулжээ. Кальерийн энэ ном өнөө үед ч ач холбогдлоо алдаагүй байгаа төдийгүй дипломатчдыг бэлтгэн гаргадаг өрнө, дорнын бүх сургуульд заавал үзэж судлах сурах бичиг болон ашиглагддаг. Уг номыг гарснаас хойш дипломат ажиллагааг Макиавеллизм буюу арга заль, ов мэх хэрэглэж, худал хуурмаг явдлыг цээрлэдэггүй зүйл буюу залилан мэхлэх урлаг, дэг жам мөрдсөн ёсорхог явдал, зүгээр сууж тансаг амьдрахын нэр гэж үзэхээ больж, мөн Н. С. Хрущевын хэлсэнчлэн дипломат ажиллагаа гэдэг нь туйлын энгийн юм бус харин онолын үндэслэлтэй, ёс суртахууны өндөр зарчимд тулгуурласан шинжлэх ухаан, ур чадвар гэж үзэх болсон юм.<sup>6</sup> Английн дипломат, судлаач, улс төрч, олон улсын харилцааны жинтэй бүтээл гаргасан Х.Никольсон бүтээлдээ “Дипломат ажиллагааны зориулалт нь олон улсын итгэлцлийг бий болгох явдал юм” гэж тэмдэглэжээ.

Аливаа улс гүрэн дипломат ажиллагаагаар дамжуулан нэр хүндээ олон улсын хэмжээнд бэхжүүлж, харилцан ашигтай хамтын ажиллагаа явуулах замаар улсынхаа ашиг сонирхлыг хамгаалж байдаг бөгөөд улс хоорондын харилцаанд харилцан итгэлцэл тун чухал юм. Монгол улсын хувьд ч гэсэн дипломат ажиллагаагаар дамжуулан олон улсын түвшинд Монголын нэр хүндийг өргөх, Монгол улсад, монгол хүндээ итгэдэг болгох нь улсын маань аюулгүй байдалд чухал ач холбогдолтой гэж үзэн дээрх үзэл баримтлалдаа тийнхүү зааж өгчээ. Олон улсын хамтын нийгэмлэг (дэлхийн нөлөө бүхий улс орнууд) болон Монгол улсын хооронд итгэлцлийг бий болгох нь олон улсын хэмжээнд Монгол улсын байр суурийг бэхжүүлж, улмаар үндэсний аюулгүй байдлыг хангахад нэн чухал болох нь илэрхий.

Итгэлцлийг бий болгосны ашиг тусыг хүртэж улсынхаа тусгаар тогтнолыг албан ёсоор хамгаалуулж, аюулгүй байдлаа бэхжүүлж буй орон манай дэлхий дээр нэг бус байна. Тухайлбал АНУ-нь харилцаандаа бүрэн итгэлцлийг бий болгосон Израиль улсыг ямарч нөхцөлд хамгаалж, ямагт

---

6. В.И. Попов, “Современная дипломатия: теория и практика, Дипломатия – наука и искусство”. Москва, “Международные отношения” 2003., стр. 13, 18

МУ-ын аюулгүй байдлыг хангахад олон нийтийн дипломат ажиллагааны гүйцэтгэх үүрэг

талд нь орж, улайран өмгөөлж хаацайлж байдгийг дэлхий даяараа мэднэ. АНУ-ын ерөнхийлөгч Барак Обама 2011 онд хэлсэн үгэндээ “АНУ болон Израйлийн хоорондын амин холбоос тасрашгүй бат бөх бөгөөд Израйлийн аюулгүй байдлыг хангахын тулд АНУ тууштай зүтгэдэг” гэж хэлсэн нь үүний нэг нотолгоо юм. АНУ-ын хувьд их гүрний тодорхой ашиг сонирхол байгаа нь мэдээж боловч Израиль улсын нутаг дэвсгэр, баялгаас болж, эсвэл зөвхөн геополитик, стратегийн ашиг сонирхлын үүднээс тийнхүү хандаж байгаа хэрэг бус харин Израиль хүн, Иудей үндэстэн гэдэг бол Бурханаас заяагдсан агуу үндэстэн, тэдэнд сайн хандаж, Израильчуудад сайныг үйлдэх нь АНУ-ын оршин тогтнохын үндэс суурь гэдэгт итгэдэг учраас Америкчууд нутаг дээрээ ч гэсэн еврей гаралтай хүмүүст сайн хандаж, тэдэнд үйлчилдэг ажээ. Эргээд хариуд нь тэднээсээ ч ашиг тусыг нь хүртсээр ирсэн бөгөөд өдгөө АНУ-ын гол томоохон нэр хүнд бүхий байгууллага, компани, сургалт судалгааны их сургуулиудын голлох боловсон хүчин нь еврей гаралтай хүмүүс байдаг. Мөн Нобелийн шагнал хүртэгсдийн 20 гаруй хувь нь еврейчүүд юм.

“Дипломат эрх зүйн арга нь хүч хөрөнгө нэг их шаардахгүй боловч тохироо нь бүрдвэл маш их өгөөжтэй байдаг билээ. Сайн санааны уур амьсгал бүрдүүлэх, найрсаг хандлага бий болгох, тухайн орны нэр хүндийг өргөх, тусламж туслалцаа авах, худалдаа хөрөнгө оруулалтыг дэмжих замаар зонхилох орнуудын бодитой ашиг сонирхлыг буй болгох гэх мэт. Энэхүү үр өгөөжийг тусгаар тогтносон байдал, аюулгүй байдлаа улам бэхжүүлэхэд чиглүүлэх хэрэгтэй гэдэг нь хэн бүхэнд ойлгомжтой.”<sup>7</sup> гэжээ. Тэгэхээр Монгол улсын хувьд одоогийн нөхцөл байдалд аюулгүй байдлаа дипломат аргаар хэрхэн бэхжүүлэх вэ? Үүнийг тодорхой мэдэхийн тулд дипломат ажиллагааны зорилго, зорилт болон чухам ямар ажиллагааг сонгох нь илүү дээр болохыг судалж мэдэх хэрэгтэй.

Дипломат ажиллагааны гол зорилт бол улс орныхоо болон иргэдийнхээ ашиг сонирхлыг хамгаалах явдал гэж олон орны судлаачид үзэж байна. Аливаа улсын явуулж буй гадаад бодлого, дипломат үйл ажиллагааг улсдаа болон иргэддээ ямар үр ашигтай байна вэ гэдгээр нь сайн, үр дүнтэй эсвэл бодитой, тодорхой гэх мэтчилэн дүгнэж болох юм. Монгол улсын Гадаад Харилцааны Яамны сайд Л. Болдын хэлснээр “Эдүгээ цаг үе бол сайн гадаад бодлого л улс орны аюулгүй, бүрэн бүтэн байдлыг хангадаг болсон тийм эрин үе юм.”<sup>8</sup>

Дипломат ажиллагааны нэг том төрөл болох, сүүлийн үед их гүрнүүд ихэд анхаарал хандуулах болсон олон нийтийн дипломат ажиллагаа нь

7. Ц. Батбаяр, “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг улс төр-дипломатын аргаар хангах зарим асуудал”, “Стратеги Судлал” сэтгүүл, №38 (2/2007)

8. Л. Болд “Дэлхий хэмээх орон зайд шинэ монгол хүн гэсэн цаг хугацааг бий болгохыг эрмэлзэнэ.” “Өдрийн Сонин”, 2012 оны 10-р сарын 5-ны дугаар

Монгол улсын аюулгүй байдлыг хангахад чухал үүрэгтэй. Учир нь олон нийтийн дипломат ажиллагаа буюу Ардын Дипломат ажиллагаа нь хамгийн энгийн хүрээнд, хамгийн богино хугацаанд жирийн олон нийтэд хүртээмжтэй, өгөөжтэй хэрэгжиж чаддаг учраас түүний үзүүлэх үр нөлөө, ирээдүйд авчрах ашиг тус нь маш их байдаг. Уг дипломат ажиллагааг хэрэгжүүлсэн улс орнууд ард иргэддээ ач тустай олон сайн зүйлийг бий болгож чадаж байна. Тухайлбал АНУ нь олон нийтийн дипломат ажиллагааг тун их чухалчилж үздэг бөгөөд Төрийн Департаментед нь уг ажиллагааг хариуцсан бүхэл бүтэн институт, байгууллага шууд харьяалагдан ажилладаг. Шалтгаан нь олон нийтийн дипломат ажиллагаа нь дипломат ажиллагааны бусад олон хэлбэрүүдээс илүүгээр тус улсын аюулгүй байдалд шууд болон тойруу замаар нөлөөлнө гэж үзэж тийнхүү анхаардаг байна.

Олон нийтийн дипломат ажиллагааг хэрэгсдэггүй аливаа улс орон өнөөгийн дэлхий ертөнцөд голлох байр суурийг эзлэхгүй бөгөөд олон улсын хэмжээнд өөрийн орны эрх ашгийг хамгаалж, аюулгүй байдлаа хангаж үл чадна. Улс төрийн бодлого, гадаад бодлого, түүний хэрэгжилт болсон дипломат ажиллагаагаар дамжуулан төр засаг, энгийн иргэдийн хоорондын харилцааг тодорхойлох болсон даяаршиж буй харилцаа холбооны үйл явц, түүний гүйцэтгэх үүрэг нь олон нийтийн дипломат ажиллагаанд их ач холбогдол өгөхөд аяндаа хүргэж байгаа бөгөөд ялангуяа дэлхийд тэргүүлэгч орнууд буюу их гүрнүүдийн засгийн газрууд энэхүү дипломат ажиллагаанд анхаарал хандуулахаас аргагүй болоод буйг өнөөгийн дэлхий ертөнцийн дүр төрх, хэв маяг харуулж мөн шаардаж байна.

Олон нийтийн дипломат ажиллагаа гэж чухам юу вэ? Энэ нэрийг хэн хэзээ өгсөн талаар товч өгүүлбэ. АНУ-ын дипломат ажилтан байсан Эдмунд Галлион гэдэг хүн 1960-аад оны дундуур анх энэхүү үгийг гаргаж ирсэн гэдэг. Тодруулбал, 1965 онд АНУ-ын Бостон хотын ойролцоо орших Тафтсын Их сургуулийн нэг салбар болох Хууль зүй болон Дипломат Ажиллагааны Флетчер Сургууль дээр Эдвард Р. Марроугийн нэрэмжит Төвийг байгуулахтай холбогдуулан тус сургуулийн Дипломат Ажиллагааны Флетчер сургуулийн захирал, дипломат асан Эдмунд Галлион олон нийтийн дипломат ажиллагаа гэдэг үгийг анх хэрэглэсэн түүхтэй ажээ.<sup>9</sup> Тэрээр олон улсын хэмжээнд мэдээллийг түгээх, соёлын харилцаатай байх тэр үйл явцыг илэрхийлэхдээ энэ үгийг анх хэлжээ. Эдвард Марроугийн төвийн үйл ажиллагааг танилцуулсан товхимолд олон нийтийн дипломат ажиллагааны бодит үүргийг заахдаа “Гадаад бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэхэд олон нийтийн санаа бодол, хандлагыг тусгах,

9. Д. Цолмон “The US Foreign Policy and Public Diplomacy in the Curriculum of SFS, NUM”, “Олон Улсын Харилцаа” сэтгүүл, 2003 №2. 231(08). х.33

МУ-ын аюулгүй байдлыг хангахад олон нийтийн дипломат ажиллагааны гүйцэтгэх үүрэг нөлөөлөл нь байх явдал юм<sup>10</sup> гэж бичсэн байдаг.

Аливаа улсын явуулж буй дипломат үйл ажиллагаа нь тухайн улсын нэрийн хуудас болдог. Тиймээс дипломат ажиллагаа нэн чухал бөгөөд олон төрөл хэлбэртэй байдаг. XX зууны дунд үеэс дипломат ажиллагааг зөвхөн хязгаарлагдмал хүрээнд гүйцэтгэхээ больж, үйл ажиллагаа нь аажмаар өөрчлөгдөн илүү чөлөөтэй, ил тод болсон юм. Өнөө үед дипломат ажиллагаанд дипломат албаны мэргэжлийн хүмүүсээс гадна төрийн албан хаагчид, бизнес эрхлэгчид, эмэгтэйчүүд, мөн олон нийтийн, шашны, хүний эрхийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчид, түүгээр ч үл барам нэр хүндтэй хувь хүмүүс хүртэл идэвхтэй оролцох болсон учраас үүнийг ардын буюу олон нийтийн дипломат ажиллагаа хэмээн нэрлэх болжээ.

Техник технологийн хөгжил хүн төрөлхтөний түүхэнд байгаагүйгээр хэзээ хэзээнийхээсээ илүү хурдацтай дэвшин хөгжиж буй өнөө үед сансрын хиймэл дагуулын тусламжтайгаар төрөл бүрийн сувгийг хүлээн авч, маш богино хугацаанд асар их мэдээллийг интернетээр дамжуулан авч, өгч, солилцох боломжтой болсон учраас хүмүүсийн хоорондын харилцаа эрс идэвхжиж, жирийн иргэд тив дамнан харилцах болсон билээ. Иймээс техникийн дэвшил нь олон нийтийн дипломат ажиллагааг эрчимтэй явуулахад гол түлхэц болж, мөн олон улсын харилцаанд нөлөөлөх нь ихсэж байгааг анхаарах шаардлагатай болоод байна. Энэ нь улсын аюулгүй байдалд нөлөөлдөг учраас тэр юм.

Улс гүрнүүдийн хоорондын харилцаа, хамтын ажиллагаа нь иргэд хоорондынх нь харилцаан дээр үндэслэдэг. Иргэд хоорондын харилцаа, аливаа улсын талаарх энгийн иргэдийн ойлголт, тэдэнд төрсөн болон хадгалагдсан сэтгэгдэл нь улсын аюулгүй байдалд шууд болон дам холбоотой байж болно. Тухайлбал, АНУ нь олон нийтийн дипломат ажиллагааг явуулах гол зэвсэг болсон нийтийн мэдээллийн сүлжээг (интернет, гар утас, зурагт, кабелийн сувгууд буюу хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг) ашиглан лалын ертөнцтэй харилцаагаа сайжруулахыг чармайж байна. Тэгэхдээ жишээлбэл хүн амынх нь бараг 60 гаруй хувь нь мусульман болох Чад улсад болон лалын шашинтай бусад улс оронд АНУ-г үзэн ядаж, америкчуудад дургүйцдэг байдлыг өөрчлөхын тулд АНУ-д ажиллаж, амьдарч байсан, одоо тэнд суралцаж, амьдарч байгаа лалын шашинтнуудын санал сэтгэгдэл, тэдний сайн сайхан аж амьдралын тухай дээрх хэрэгслүүдээр нэвтрүүлж, оюутан солилцооны хөтөлбөрүүд, техник мэргэжлийн сургалт болон англи хэлний сургалтууд, мөн эдийн засгийн хувьд бололцоо олгох арга замаар дээрх орнуудын ялангуяа залуучууд, өсвөр үеийнхэн рүү чиглүүлсэн олон үйл ажиллагааг явуулж байна. Ийнхүү залуучуудыг дээд боловсрол эзэмших, илүү өндөр дээд түвшинд

10. <http://www.publicdiplomacy.org/>

МУ-ын аюулгүй байдлыг хангахад олон нийтийн дипломат ажиллагааны гүйцэтгэх үүрэг  
ажиллаж амьдрах бололцоогоор хангаж, улмаар аюулгүй, эдийн засгийн хувьд найдвартай эх үүсвэртэй болгож, ирээдүйг нь баталгаажуулснаараа АНУ-д талархдаг, эерэг сэтгэгдэлтэй болгож байгаа бөгөөд энэ нь АНУ-ын аюулгүй байдалд сайнаар нөлөөлнө хэмээн үзэж байна. АНУ-д суралцаж, бэлтгэгдэж, боловсрол эзэмшиж, тэндээс бизнесийн дэмжлэг авч хөл дээрээ боссон залуус тэр газарт аюул учруулж, алан хядах үйл ажиллагааг явуулах санаа өвөрлөх нь ховор. Ер нь хүн ажиллаж, амьдарч, суралцаж байсан газраа элэгтэй ханддаг нь нийтлэг үзэгдэл юм.

Хятад, Энэтхэг болон Европын орнуудаас өвөрмөц өөр онцлогтой Монгол улсын хувьд өөрийн онцлогийг тусгасан олон нийтийн дипломат ажиллагаагаар дамжуулан улсынхаа нэр хүндийг өргөж, гадаад улс орнуудад Монголын талаар эерэг сэтгэгдэл төрүүлж, тэрхүү сэтгэгдэл, эерэг нэр хүндийг бэхжүүлэх нь улсын аюулгүй байдлыг хангахад чухал хувь нэмэр болно. Түүнчлэн, монгол хүний нэр хүндийг өргөж явахын чухлыг иргэддээ ойлгуулж, гадаадад ч, эх нутагтаа ч харийн хүмүүстэй зөв харилцах нь бас нэг алхам болно. Үүний тулд олон нийтийн дипломат ажиллагаагаар мэргэшсэн дипломатуудыг Монголд сургаж бэлтгэх цаг хэдийнэ болжээ. Дэлхийн нөлөө бүхий АНУ, Англи зэрэг улс орнуудад олон нийтийн дипломат ажиллагааг бусад дипломат ажиллагаанаас илүүтэй чухалчилж, уг дипломат ажиллагааг явуулдаг тусгай төв болон сургалтын байгууллагуудаар дамжуулан мэргэжилтнүүдийг тусгайлан бэлтгэж байна. Түүгээр ч үл барам, улс орныхоо хувь нэмэр оруулсан байгууллага, хувь хүмүүсийг шалгаруулан урамшуулдаг тогтолцоо нь бүрдэж, дээрх чиглэлээр төрийн дээд удирдлагууд нь чиг удирдамж өгч, судалгаа шинжилгээг урамшуулан хөхүүлдэг болжээ. Жишээлбэл, АНУ-ийн Төрийн Департамент нь хэрэгжүүлсэн байгууллага, хувь хүмүүст Бенжамин Франклины нэрэмжит “олон нийтийн дипломат ажиллагааны шагнал” - ыг олгодог ажээ.

Иймд, засгийн газрууд, хэрэгжүүлэгч агентлагууд, тэр дундаа улс орноо төлөөлдөг, олон улсын харилцаанд оролцож буй иргэддээ гүүр нь болох ёстой дипломат албаныхан үүнийг бүх шатандаа анхаарч ажиллах хэрэгтэй байна. Олон нийтийн дипломат ажиллагаа нь харьцангуй шинээр гарч ирж буй ойлголт боловч улс орнууд гадаад бодлогоо боловсруулан хэрэгжүүлэхдээ олон нийтийн буюу энгийн иргэдийн санаа бодол, хандлага, хүсэлтийг харгалзан үзэх болж, аливаа шийдвэрийг гаргахдаа нэн тэргүүнд дотооддоо зөвшилцөх нь туйлын чухал болохыг ухаарч, ихэнх улс орнууд гадаад хэргийн яамдынхаа дэргэд олон нийттэй харилцах тусгай алба хэлтэс буюу Public Diplomacy Office-г байгуулан ажиллах болсон юм.

Улмаар, хэвлэл мэдээллийнхэн, нөлөө бүхий бүлэг нийгэмлэгүүд, иргэдийн сайн дурын байгууллагын төлөөлөгчид болон хувь хүмүүстэй харилцаж, саналыг нь сонсож, гадаад улсад зорчиж буй өөрийн орны иргэдээрээ дамжуулан гадаад бодлогоо тайлбарлан таниулах, улс орныхоо талаар эерэг, таатай сэтгэгдлийг бий болгох, улсынхаа нэр хүндийг өргөх, олон нийтийн дипломат ажиллагаагаар дамжуулан нөлөө бүхий байгууллага, компани болон хувь хүмүүсийн санаа бодлыг дээд шатны шийдвэр гаргалтандаа тусгах аргыг өнөө үед өргөн хэрэглэх болжээ. Монгол улсын хувьд үүнийг анхаарч хэрэгжүүлэх цаг хэдийнээ болжээ. Ингэж байж гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болсон Монгол улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг улс төр-дипломатын аргаар хангах . . . зорилт маань үр дүнтэй хэрэгжих болно.



## АШИГЛАСАН НОМЗҮЙ

1. “Монгол Улсын Гадаад Бодлогын Үзэл Баримтлал”, УБ. 1994
2. “Монгол Улсын Гадаад Бодлогын Үзэл Баримтлал”, УБ. 2011
3. “Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын тухай хууль”. 2001.12.27., Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл. УБ, 2004.
4. “Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлал”, 2010-7-15. УБ
5. “Монгол Улсын Үндсэн Хууль”, I-р бүлэг, 11-р зүйл
6. В.И. Попов, “Современная дипломатия: теория и практика, Дипломатия – наука и искусство”, Москва, “Международные отношения” 2003.,
7. Д. Цолмон. “The US Foreign Policy and Public Diplomacy in the Curriculum of SFS, NUM”, “Олон Улсын Харилцаа” сэтгүүл, 2003. №2. 231 (08)
8. Ц. Батбаяр, “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг улс төр-дипломатын аргаар хангах зарим асуудал”, “Стратеги Судлал” сэтгүүл, №38 (2/2007)
9. <http://www.publicdiplomacy.org/>
10. Remarks, Hillary Rodham Clinton, Secretary of State, National Museum, Beijing, China, May 4, 2012; Especially for Students: Remarks at the People-to-People Dialogue Plenary Session; Saturday, May 05, 2012, 2:27:21 AM;